



БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
XII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 03 өдөр

Дугаар XII/05

Булган сум

Булган аймгийн хөгжлийн 2022 оны
төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын найм дах удаагийн сонгуулийн 2021 оны V/02 дугаар тогтоолоор баталсан “Булган аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, цаашдын зорилтын тухай аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-ийн тавьсан мэдээллийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V дугаар Хуралдаанаар баталсан Булган аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөнд 14 зорилтын, 95 арга хэмжээг тусган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Үүнд: Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 5 зорилтын 38 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 90.7 хувьтай.

Эдийн засгийн бодлогын хүрээнд 5 зорилтын 42 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 80.2 хувьтай.

Засаглалын бодлогын хүрээнд 2 зорилтын 6 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 71.7 хувьтай.

Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилтын 9 арга хэмжээний хэрэгжилт 88.9 хувь, нийт дундаж 84.4 хувьтай үнэлэгдэн тодорхой үр дүн гарсан гэж үзлээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3 дах заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын найм дах удаагийн сонгуулийн XII Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Булган аймгийн хөгжлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хангалттай үр дүнд хүрсэн гэж үзсүгэй.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт хийж, 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ анхаарч удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Ариун-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Батжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЭРДЭНЭБАТ